

в/ хэрэв буруутай бодсон этгээд нутаг дэвсгэрт нь өөрийн хуулийг үндэслэн шийдвэр гаргасан Хэлэлцэн Тохирогч Зтгээд хэргийг авч хэлэлцэх тухай зохих хэлбэрээр цаг тухайд нь иэдэгдсэн боловч шуух ажшлагаанд оролцоогүй буюу зрхийн чадваргүй уед зохих хэлбэрээр төлөөлүүлж болох байсан явдлаа ашиглаагүй бол;

г/ хэрэв нутаг дэвсгэрт нь хулээн зөвшөөрөх буюу гуйцэтгэх уед Хэлэлиэн Тохирогч Зтгээдийн шуухээс хоёр этгээдийн хоорондох нэг хэргийг урьд авч хэлэлцэн гаргасан хуулийн хучин төгөлдөр болсон шийдвэр байхгүй бол.

Тавин наймдугаар зуйл

Эд хөрөнгийн биш шийдвэрийг
хулээн зөвшөөрөх

Хэрэв энэхуу Гэрээний 57-р зуйлд заасан нөхцөл бүрдсэн бол Хэлэлцэн Тохирогч нэг Зтгээдийн шуухийн эд хөрөнгийн биш шийдвэрийг Хэлэлцэн Тохирогч нөгөө Зтгээдийн нутаг дэвсгэрт дахин авч хэлэлцэхгүйгээр хулээн зөвшөөрнө.

Тавин есдугээр зуйл

Иргэдээо харилцан тэтгэвэр төлөх
эрхийн бичиг баримтыг хулээн
зөвшөөрч гуйцэтгэх

Хэлэлцэн Тохирогч нэг Зтгээдийн нутаг дэвсгэр* асран хамгаалах, харгалзан дэмжих хэргийг авч хэлэлцэх эрх бүхий байгууллагаас уйлдэж, иргэдээс харилцан тэтгэвэр төлөхтэй холбогдсон шаардлага агуулсан бичиг баримт нь хэрэв энэхуу Гэрээний 57-р зуйлд заасан нөхцлийг бурдуулсэн энэ зуйлийн заалтыг тэтгэврийн хэрэгт хэрэглэж болох бичиг баримт байвал Хэлэлцэн Тохирогч нөгөө Зтгээдийн нутаг дэвсгэрт туунийг хулээн зөвшөөрч гуйцэтгэвэл **зохино**.